

“ХАЛХЫН ҮЙСЭН ЦААЗ”-ЫГ СУДЛАХ АСУУДАЛД

Э.ЖИГМЭДДОРЖ

Товч агуулга: Монголын түүх, соёлын өв их уламжлалын нэг бол хус модны үйсэн дээр бичсэн бичгийн дурсгал юм. 1970 онд Монгол улсын Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Хар бухын балгаснаас мянга гаруй үйсэн бичиг олдсон нь Монгол төдийгүй Төв Азийн түүх, соёлын чухал дурсгалд зүй ёсоор тооцогдож байна. Хар бухын балгаснаас олдсон үйсэн бичгийн дурсгалын доторхи нэгэн сонирхолтой хэсэг нь XVI-XVII зууны эхэн үед Халхын ноёдын удаа дараагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон цааз бичиг (“Халхын үйсэн цааз”) болой. Энэ өгүүлэлд “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн онцлог болон уг сурвалж дахь XVI-XVII зууны Монголын түүх, хууль цааз, аж ахуй, соёлын түүхэнд холбогдох зарим мэдээ баримтын талаар товч өгүүлэхийг зорив.

Түлхүүр үг: Үйсэн бичиг, Хар бухын балгас, Халхын үйсэн цааз,

Монголчууд түүхийн туршид олон зүйлийн үсэг бичиг зохиож, хад чулуунаас эхлэн хус модны үйс, бөс даавуу, торго, төрөл бүрийн цаасан дээр ном судараа бичиж иржээ.

Монголын түүх, соёлын өв их уламжлалын нэг бол хус модны үйсэн дээр бичсэн бичгийн дурсгал юм. Монголчуудын үйсэн бичгийн дурсгалын дотор 1970 онд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг Хар бухын балгаснаас олдсон мянга гаруй үйсэн бичиг томоохон байр эзэлнэ.

Х.Пэрлээ Хар бухын балгасны үйсэн бичгийн дурсгалын дотроос цаазыг гараар хуулбарлан, галиг, зарим тайлбарын хамт *Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг*¹ нэрээр 1978 онд Улаанбаатар хотод нийтлүүлснээс хойш судлаачдын анхаарлыг татсаар иржээ.²

¹ Пэрлээ, Х. “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг”. Тэргүүн дэвгэр. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, *Monumenta historica*. Tom. VI. Fasc.1, 1974. 5-139 (хойшид “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг” хэмээн товчилно). Тэрбээр үүнээс гадна дараах өгүүллийг хэвлүүлсэн буй. Үүнд: Пэрлээ, Х. “Халхын үйсэн ном”, *Шинжлэх ухаан альбурал* №4, 1972, 67-79; Пэрлээ, Х. “Үйсэнд бичсэн цаазын оодос”, *Монголын судлал (Studia Mongolica)*. Tom.IV (12). Fasc.7, 1976, 291-293.

² Өмнөх судалгааны талаар дараах өгүүлснээс дэлгэрүүлэн үзнэ үү: Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз дахь Чингис хааны 9 орлогийн магтаал”, *Eurasian Nomadic Pastoralism: History, Culture, Environment*. CNEAS Report 22. Center for Northeast Asian Studies, Tohoku University. Sendai, 2016. p.27-47.

Хар бухын балгасны тууриас олдсон үйсэн бичгийн дурсгалыг 1990-ээд оноос Бонн их сургууль (Bonn University)-ийн профессор Klaus Sagaster-ын хүчин зүтгэл, шаргуу хөдөлмөрийн үр дүнд ХБНГУ-д сэргээн засварлаж, Монголын соёлын өвийг хадгалан хамгаалах, судлан шинжлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Үйсэн бичгийн сэргээн засварласан эхийг 2012 онд Монгол улсын Үндэсний номын санд хүлээлгэн өгсөн нь эдүгээ үнэт ховор номын фондод байна.

Профессор Klaus Sagaster, Итали улсын монголч эрдэмтэн Dr. Elisabetta Chiodo нар үйсэн бичгийн дурсгалаас булдын шашны холбоотой хэсгийг тусгайлан судалж, эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэл³, цуврал хоёр боть⁴ ном хэвлүүлсэн юм. Эдгээр бүтээл нь Монгол судлал, монголын соёл, шашны судалгаанд чухал ач холбогдолтой болжээ.

Хар бухын балгасны тууриас олдсон үйсэн бичгийн дурсгалын доторхи нэгэн сонирхолтой хэсэг нь *Халхын үйсэн цааз* юм. Бидний судалгаагаар “Халхын үйсэн цааз”-ын агуулга нь:

1-д XVI зууны сүүлчээс XVII зууны дунд үе хүртэл Халхын язгууртан ноёдын арван найман удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон цааз,

2-т Зургаан түмний их түгэлийн бичиг (*jirGuGan tUmen-i ycke tUgeliin bicig*) хэмээн нэрлэсэн Чингис хааны 9 өрлөгийн магтаал гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна⁵.

Халхын үйсэн цааз бол XVI зууны сүүл XVII зууны тэргүүн хагасын Монголын түүх, хууль цааз, аж ахуй, соёл, шүтлэг бишрэл, уран зохиолыг судлах бичгийн сурвалжийн нэг юм. Тус сурвалжийг түүх, хэл шинжлэл, хууль цааз, уран зохиол, эх бичиг судлалын зэрэг шинжлэх ухааны судалгааны арга зүйн үүднээс

³ Chiodo, E and Sagaster, K. “The Mongolian and Tibetan Manuscript on Birch bark From Xarbhyn Balgas: A Preliminary Description”, *Zentralasiatische Studien*, 25. 1995, 28-42; Chiodo E. “A Mongolian Hymn to Qongsim Bodisung on birch bark from Xarbhyn Balgas (Bulgan aimag)” in *Ural-Altaische Jahrbücher. Neue Folge* 15. Harrassowitz verlag, 1997/1998, 223-249; Chiodo, E. “Some observations on two texts to avalokitasvara from Xarbhyn balgas”, in *Mongolica* (An International Annual of Mongol Studies). Vol.10 (31). Seventh International Congress of Mongolists Vol. II, 2000, 369-378; Chiodo, E. “On the Identification of a Mongolian Dharani from Xarbhyn Balgas”, in *Ural-Altaische Jahrbücher Neue Folge* 18. Harrassowitz verlag, 2003/2004, 123-140; Chiodo, E. “Die mongolische Manuskripte auf Birkenrinde aus Charbuchyn Balgas”, *Dschingis Khan und seine Erben: Das Weltreich der Mongolen. Exhibition Catalogue*. München: 2005, 112-116.

⁴ Chiodo, E. *The Mongolian Manuscripts on Birch from Xarbhyn Balgas in the Collection on the Mongolian Academy of Sciences. Part 1*. Harrassowitz Verlag, Wiesbaden: 2000. 305 p + facsimiles; Chiodo, E. *The Mongolian Manuscripts on Birch from Xarbhyn Balgas in the Collection on the Mongolian Academy of Sciences. Part 2*. Harrassowitz Verlag, Wiesbaden: 2009., 338 p + facsimiles.

⁵ Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз дахь Чингис хааны 9 өрлөгийн магтаал”. *Eurasian Nomadic Pastoralism: History, Culture, Environment*. CNEAS Report 22. Center for Northeast Asian Studies, Tohoku University. Sendai: 2016, 39.

нарийвчлан судлах, салбар дундын хавсарсан судалгааны үүднээс тусгайлан судлах шаардлага байсаар байна.

Энэ өгүүлэлд “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн онцлог болон уг сурвалж дахь XVI-XVII зууны Монголын түүх, хууль цааз, аж ахуй, соёлын түүхэнд холбогдох зарим мэдээ баримтын талаар товч өгүүлэхийг зорив.

1. “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн зарим онцлог

Монгол улсын Үндэсний номын санд буй “Халхын үйсэн цааз”-ын эх нь хус модны үйсний өнгөн талыг хуулан цэвэрлэж, хуудасны ар болон өвөр талд уйгуржин монгол бичгээр хар бэхээр бичсэн, ном хэлбэртэй, 10х14 см хэмжээтэй, нэг нүүрэнд 4-8 мөрөөр бичээс бүхий 112 нүүрээс бүрдэнэ.

Үндэсний номын сангийн каталогид Халхын үйсэн цаазын сэргээн засварласан эхийг “Халхын үйсэн дээр бичсэн хууль цааз”⁶ нэрээр бүртгэж, гэрэл зургийг авч цахим хэлбэрт оруулсан байна. Энэ нь 001-ээс 0080 хүртэл дугаарласан нийт 80 зураг (үүнээс 42 зурагт үйсэн хуудасны хоёр нүүр, 38 зурагт нэг нүүр)-аас бүрдэх ажээ.

ХБНГУ-ын Бонн их сургуулийн профессор Klaus Sagaster багш үйсэн бичгийн дурсгалыг сэргээн засварласан ажлын гэрэл зургийн дотор “Халхын үйсэн цааз”-ыг Law texts гэсэн нэрээр хадгалжээ. Law texts нь 001-ээс 0081 хүртэл дугаарласан нийт 81 зурагтай. Энд зөрүү гарч байгаа мэт боловч эх бичгийн 112 нүүр тохирч байна.

“Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн 056 (014) дугаар нүүрний 8 мөр бичээс бүдгэрч уншихад бэрх болсон, “Зургаан хошууны их цааз”-ын эхэн хэсэг байхгүй, “Шар туулай жилийн их цааз”-ын зөвхөн эхний нэг хуудас малтлагын явцад олдсон байдаг. Иймд “Халхын үйсэн цааз”-ын эх бүрэн гүйцэт хэмээн ойлгож болохгүй.

Үүнээс гадна ХБНГУ-д сэргээн засварласан Хар бухын балгасны бусад үйсэн бичгийн дурсгалын дотор хууль цаазын хэсэг бололтой 10 гаруй жижиг тасархай байна. Тэдгээрийн ихэнх нь галд өртөж, урагдаж, үсэг бичгийг уншихад бэрх болсон хэдий ч yalatu kUmUn (гэрэл зургийн дугаар 21253: 01-06), mori ab (гэрэл зургийн дугаар 21313: 007-1,2), yala bUU og (гэрэл зургийн дугаар 21320: 0078-2), nigen temege ab (гэрэл зургийн дугаар 21320: 00713-1), yala-tai bolba (гэрэл зургийн дугаар 21320: 00798-1, 2) гэх мэтээр тэмдэглэснээс үзэхэд цааз бичигт хамаатай болох нь мэдэгдэнэ. Эдгээрийн зарим нь “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн тасархай байж болох хэдий ч үйсний байдал, бичгийн хэв зэргээс харахад зарим нь өөр хууль цаазын хэсэг бололтой.


⁶ *Халхын үйсэн дээр бичсэн хууль цааз*. Монгол улсын Үндэсний номын сан. Бүртгэлийн дугаар 8590.

Хар бухын балгаснаас олдсон үйсэн бичгийн дурсгалын дотор дэвтэрлэн үдсэн “Халхын үйсэн цааз”-аас гадна оор цааз бичгийн хэсэг байгаа хэмээн үзэж болох талтай байна.

“Халхын үйсэн цааз”-ын эхийг дэвтэрлэн үдсэн хуучин ул мөр буй богоод хуудас болон нүүр, мөрийн бичгийн хэв, зурлага өөр, зарим тохиолдолд хугарч элэгдсэн хуудас буюу нүүрийн бүтэн хэсгээс эхэлж бичсэн зэрэг зүйл ажиглагдана. Энэ нь Халхын ноёдын чуулган болох үед урьдчилан бэлтгэсэн үйсэн хуудсан дээр цаазыг сийрүүлэн бичиж, дараа дараагаар бичээч нар залган нэмж байсныг илтгэнэ. Тухайлбал,

- Үйсэн цаазын эх бичигт хугарч элэгдсэн хуудасны бүтэн хэсгээс эхэлж бичсэн жишээ нь “Мичин жилийн их цааз”-ын 041а нүүр юм.
- Үйсэн цаазын 27а, 28б, 29а,б зэрэг нүүр, хуудасны бичгийн хэвийг ажиглахад б, г(к), ж үсгийн зурлага ижил төстэй буюу энэ хэсгийг нэг хүн бичсэн бололтой.

Жишээ зураг. Урагдаж тасарсан үйсэн хуудасны бүтэн хэсгээс эхлэн бичсэн байдал



Эх бичгийн зураг №041а.

“Халхын үйсэн цааз”-ын эх бичигт шинэ цааз эхлэн бичих бол мөрийн эхэнд, зарим хүндтэй үг (ном, ума хум, сүм, бурхан, ноён г.м.)-ийн өмнө бирга (birga) тавьсан байна. Халхын ноёдын 18 цаазаас даруй 12 цаазыг эхлэн бичих үед бирга тавьсанаас үзэхэд энэ нь тухайн цагийн бичгийн тогтсон ёс байжээ. Үүнд,

- Цаазын эхэнд бирга (тэмдэг) тавьсан нь “Усан үхэр жилийн өчүүхэн цааз”, “Модон луу жилийн цааз”, “Төмөр гахай жилийн өчүүхэн цааз”, “Усан үхэр жилийн өчүүхэн цааз”, “Эр Модон барс жилийн дөрвөн хошууны өчүүхэн цааз”, “Эр модон барс жилийн Сайхны сүмийн цааз”, “Луу жилийн намрын өчүүхэн цааз”, “Луу жилийн нэгэн өчүүхэн эхт цааз”, “Могой жилийн сүмчний цааз”, “Номын цааз”, “Мичин жилийн их цааз”, “Өчүүхэн цааз” болой.
- К.Ф.Голстунскийн хэвлүүлсэн Халх-Ойрадын 1640 оны “Их цааз”-ын тод бичгийн эхэд шинэ цааз, шинэ мөр эхлэхийн өмнө бирга тавьсан (*Монголо-Ойратские законы 1640 года*. стр.39-71) нь тухайн цагийн бичгийн ёсны нийтлэг талыг харуулж байна.
- Д.Кара “Монголын нүүдэлчдийн ном” хэмээх бүтээлдээ XIII-XIX зууны үеийн монгол сурвалж бичиг, ном судар дахь бирга, цэг, тэмдэглэгээний тухай (*Книги Монгольских кочевников*. 1972, стр.50-52) өгүүлсэнээс үзэхэд монголчуудын ном бичгийн ёсон нь өнө эртний уламжлалтай, өөрийн өвөрмөц онцлогтой болох нь харагдана.

Жишээ зураг. Үйсэн хуудасны морийн эхэнд бирга тавьсан байдал.



Эх бичгийн зураг №077.

“Халхын үйсэн цааз”-д нэгэн зүйл заалтын үг, үсгийн ард эсвэл цаазын төгсгөлд дөрвөн төрлийн цэг [:], [::], [:::], [:::] тавьсан бол Чингисийн 9 өрлөгийн магтаалын хэсэгт өгүүлбэрийн хойно болон шүлгийн төгсгөлд [::] цэг тавьжээ. Энэ бол цааз болон магтаалын шүлгийн ялгааг харуулахын зэрэгцээ эх бичгийн онцлогийн нэг юм. XVI-XVII зууны үеийн монголын хууль цааз


болон хэл шинжлэлийн дурсгалд үг, өгүүлбэрийн төгсгөлд цэг тавьсан байгааг ажиглахад энэ нь тухайн цагийн бичгийн заншил байжээ. Жишээ нь:

- К.Ф.Голстунскийн хэвлүүлсэн Халх-Ойрадын 1640 оны “Их цааз”-ын тод бичгийн эхэд үг, өгүүлбэрийн дунд, төгсгөлд хоёр ба дөрвөн цэг тавьсан (*Монголо-Ойратские законы 1640 года*. стр.39-71),
- XVI зууны эцэс, XVII зууны эхэн үед хамаарах “Гали хийгээд монголын зуун үсгүүдийн цаазыг товчлон оршуулвай” (Р.Отгонбаатар, А.Д.Цэндина. Монгол үсэг бичгийн дээж. 2014, стр.22) хэмээх цагаан толгойн эх бичгийн үг, өгүүлбэрийн дунд, төгсгөлд хоёр болон дөрвөн цэг тавьжээ.

“Халхын үйсэн цааз”-д аливаа нэгэн цаазыг бичиж дуссаныг илтгэн *tegüs-be*, *manggalam* (өлзий хутар) хэмээсэн ба үйсэн цааз дахь Чингисийн 9 өрлогийн магтаалын төгсгөлд *daGusba* гэж бичжээ. XVI-XVII зууны үеийн монголын хууль цаазаас гадна хэл шинжлэл, шашны ном сударт *tegUsbe*, *daGusba* гэснээс үзэхэд энэ нь тэр үеийн бичгийн тогтсон ёс байсан ажээ. Үүнд,

- “Эр модон барс жилийн дөрвөн хошууны өчүүхэн цааз, “Эр модон барс жилийн дөрвөн хошууны өчүүхэн цааз, “Модон барс жилийн намрын цааз, “Гал луу жилийн өчүүхэн цааз, “Гал луу жилийн намрын өчүүхэн цааз”, “Луу жилийн нэгэн өчүүхэн эхт цааз” зэрэг дөрвөн цааз бичгийн төгсгөлд *tegUsbe*, *manggalam* гэсэн үгийг хамт, “Мичин жилийн их цааз”-д *manggalam* хэмээжээ.
- Өвөр Монголын Олон сүмээс олдсон XVI-XVII зууны үед холбогдох монгол бичгийн дурсгалт *tegUsbe*, *daGusba* гэж бичсэн (Walther Heissig, *Die mongolischen Steininschrift und Manuskriptfragmente aus Olon sUme in der Inneren Mongolei*. Göttingen, 1966. p.57-60) байгаа нь тухайн цагийн бичгийн нийтлэг ёсыг харуулж байна.

Жишээ зураг. Төгсгөлийн үг бичиж, цэг тавьсан байдал.



Эх бичгийн зураг №046а.

“Халхын үйсэн цааз”-ын хэл зүйн онцлогийн тухай Х.Пэрлээ “Үгийн тийн ялгалыг дагуулахдаа үгийн төгсгөл эр эм эгшиг, хатуу зөөлөн гийгүүлэгчийг нарийвчлан үзэлгүй, ярианы хэлний аясаар ийн, ийг, ду, ту-ийг холилдуулан залгаж буюу саланга бичсээр байжээ”⁷ (т.7) хэмээн тэмдэглэжээ.

Халхын үйсэн цаазад тийн ялгалын yin, yi, i, ni (yala-yin, mala-yin, sara-yin, pouan-i гэх мэт)-ийг эр, эм ялгалгүй тухайн үгтэй хамт буюу салангид байдлаар бичсэн байна. Үйсэн цаазад ажиглагдаж буй хэл зүйн онцлогийн заримаас дурьдвал,

- Халхын үйсэн цаазад нэг үгийг хоёр өөр янзаар бичсэн зүйл цөөнгүй тохиолдоно. Тухайлбал, yesUn, yisUn зэргийг дурьдаж болно.
- Халхын үйсэн цаазад тийн ялгалын tu-ийн оронд ихэвчлэн du, харин du-ийн оронд tu бичжээ.
- Үйсэн цаазад аса-ийн оронд tasa гэж бичжээ. Хар Бухын балгасаас олдсон үйсэн бичгийн бусад дурсгалд pouad-tasa хэмээн бичсэн зүйл тохиолдоно.
- Үйсэн цаазад зарим үг, үсгийг алдаатай бичсэн зүйл цөөнгүй байна. Жишээ нь: sUmeci хэмээх үгийн U үсгийн оронд u бичжээ.
- Үйсэн бичигт kele, jaqasa, baitala, gekUle зэрэг үгийн сүүлд [н] үсэг залгаж kelen, jaqasan, baitalan, gekUlen хэмээн бичсэн тохиолдол ажиглагдана.

⁷ Пэрлээ, Х. “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг”. Тэргүүн дэвтэр. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, *Monumenta historica*. Tom. VI. Fasc.1, 1974, 7.

“Халхын үйсэн цааз”-ын эх бичгийн онцлог нь XVI-XVII зууны үеийн Монголын хууль цааз, тухайн цагийн бичгийн тогтсон ёс, заншлыг харуулж байна.

2. “Халхын үйсэн цааз” дахь XVI-XVII зууны Монголын түүхийн зарим мэдээ баримт

“Халхын үйсэн цааз” дахь XVI-XVII зууны Монголын холбоотой мэдээ баримтыг түүхийн, хууль цаазын, уран зохиолын, аж ахуй, соёлын, шашин шүтлэгийн холбогдол бүхий хэмээн хэдэн төрөл ангилж болох юм.

“Халхын үйсэн цааз” бол XVI-XVII зууны Халхын язгууртан ноёд, тайж нарын 18 удаагийн их, бага чуулганаар хэлэлцэн тогтоосон арван найман цааз бичгээс бүрдэнэ. Халхын ноёдын чуулганаар нутаг ус эзэмших, дайн тулаан, элч улаа илгээх, цэрэг байгуулах, босуулын хэрэг, өв өвлөх, зарга заальхай зэрэг олон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тухай бүр цааз гаргаж байжээ.

Халхын үйсэн цааз нь XVI-XVII зууны язгууртан ноёдын угсаа гарал, намтар, үйл ажиллагааг улируулан шинжлэх тулгуур сурвалжийн нэг юм. “Халхын үйсэн цааз” болон Халх-Ойрадын 1640 оны “Их цааз” зэрэг сурвалжид цааз хэлэлцэгч ноёд язгууртныг жагсаан тэмдэглэхдээ тэдний угсаа язгуур, насны эрэмбэ дарааг харгалзан бичсэн зүйл ажиглагдаж буйгаас үзвэл энэ нь тухайн цагийн монголчуудын заншил байжээ.

Халхын ноёдын хэлэлцэн тогтоосон “Халхын үйсэн цааз”-д цааз хэлэлцэгч язгууртнуудыг *jasaG bariGsan noyan* (*засаг барьсан ноён*), *jasaG-un tayiji* (*засгийн тайж*) хэмээн нэрлэсэн байна. XVI зууны сүүлч XVII зууны эхэн үеийн Халхын *засаг барьсан ноёд* нь нутаг ус эзэмших, дайн тулаан, элч улаа илгээх, цэрэг байгуулах, босуулын хэрэг, өв өвлөх, зарга заальхай зэрэг олон асуудлыг хэлэлцэхэд голлох үүрэгтэй оролцож байжээ.

Халхын үйсэн цаазыг хэлэлцэн тогтоосон ноёдын бүрэлдэхүүн, нэр, цол зэргийг ажиглахад Халхын долоон хошууны чуулганыг Засагт хаан, дөрвөн хошууны чуулганыг Түшээт хаан тэргүүлэн оролцож байсан бололтой.

Үйсэн цаазыг хэлэлцсэн *засаг барьсан ноёд* нь угсаа гарлын хувьд Гөрсэнз жалайр хун тайжийн угсааны язгууртан ажээ. Энэ нь *засаг* цолыг зөвхөн Чингис хааны алтан ургийн язгууртан нар хүртэж байсныг харуулж байна.

Халхын дөрвөн хошууны цаазад нэр дурьдагдсан *засаг барьсан ноён* буюу Түмэнхэн хөндлөн цөхүр, Түшээт хун тайж (Гомбо Түшээт хан), Далай сэцэн хун тайж (Сэцэн хан), Дайчин хун тайж (Ангаахай мэргэн ноён) нар нь он цагийн

хувьд 1655 оны *Халхын зүүн гарын дөрвөн засаг*-ийн өмнөх үеийн ноёд*⁸ юм. Тодруулбал, Үйсэн цаазад гарч буй засаг барьсан эдгээр ноёдын залгамжлагчид хожим Манж Чин улсаас засаг тушаал хүртсэн байна⁹.

Цаазад гарч буй *засаг барьсан ноёд* болон тэдний залгамжлагчдын Манжтай харилцсан байдлыг тодруулан үзэхэд, засаг барьсан ноёд нь хошууны *засаг ноён*-ны тушаал хүртсэн бол засгийн тайж нар нь их төлөв хошууны сул ван гүн болсон бололтой.

Үйсэн цаазад язгууртан ноён, тайж нарыг нэрээр, цолоор, эсвэл нэр, цолыг хамтатган бичсэн гурван янзын бичлэг байна. Тухайн цаазад ноёдын нэрийг ямар дэс дарааллаар бичсэнийг нягталсанаар язгууртны угсаа гарлыг тодруулах бололцоотой. Тухайлбал, *Модон барс жилийн намрын цааз* (1614)-ын оршилд цааз хэлэлцэгч Халхын 24 язгууртны нэрийг дараалуулан бичихдээ тэдний угсаа язгуур, насны эрэмбэ дарааг баримтлан салааны тэргүүлэх ноёд буюу Оноху үйзэн ноёны ахмад хөвгүүн Абтайн удмын Түшээт хан, дөтгөөр хөвгүүн Түмэнхэн хүндлэн цөхүр, хоёрдугаар хөвгүүн Абуху мэргэн ноёны ахмад хөвгүүн Дайчин хун тайж, Амин дурал ноёны ач хүү Далай сэцэн хун тайж, Оноху үйзэн ноёны тавдугаар хөвгүүн Бахарай хошуучийн ахмад хөвгүүн Цогт хун тайж зэрэг ноёдыг тэргүүнд бичиж үүний араас бусад тайж, ноёдыг жагсаажээ¹⁰.

Үйсэн цаазад XVI-XVII зууны үеийн Монголын нийгмийн байдал, эзэн харьяатын ёсон, язгууртан, ноёд, түшмэдийн нэр, цол болон албан тушаал, шапны мяндаг, тушаал, нутгийн зохион байгуулалт зэргийг улируулан судлах түүхийн үнэ цэнэтэй мэдээ агуулагдаж байна.

Цааз бичигт нийгмийн давхраажил, албан тушаал, хэргэм, зэрэг дэвийг ялган хан хүн, боржигин (улстай боржигин, улсгүй боржигин), ямут хүн, тавнан, шигэчин, хошууны засаг барьсан дархад, долоон хошууны засаг барьсан түшмэд, хошууны ёс барьсан түшмэд, ноёдын ёс барьсан түшмэд, хатан, авхай, хуягт хүн, харц хүн, сүмч, банди гэх мэтээр тэмдэглэсний зэрэгцээ хүн (хүмүүн)-ийг дотор хан хүн, ямут хүн, эм хүн, эр хүн, хэн хүн, исэлэ хүн хэмээн ялгамжтай бичжээ.

Халхын үйсэн цаазын зарим заалтаас тухайн үеийн Монголын нийгмийн анги бүлгийн ялгаа, давхрагын онцлогыг харж болно. Тухайлбал, *Зургаан хошууны их*

* Үүнээс Мэргэн ноён Эсэр засагчийн 12-р (1655) онд өөрийн биеэр “засаг” хэмээн нэрлэгджээ.

⁹ Жигмэддорж, Э. *Халх-Манжийн улс төрийн харилцаа*. Улаанбаатар: Тэрэгт принт, 2008; Жигмэддорж, Э. Манж нар 1655 онд Халхыг зүүн, баруун гар болгон хуваасан уу? *Quaestiones Mongolorum Disputatae*. Tom. VII. Association for International Studies of Mongolian Culture. Tokyo, 2011, 118.

¹⁰ Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз дахь ноёдын удам угсааг тодруулах асуудал”, *Historia Mongolarum*. Vol. XV. Fasc. 5, №474(36). 2016, 69.

цааз-д “kUmUn: qan kUmUn abaqai qoyari daGariju donGodbasu bey-e-i alay-a malini talay-a: noyad-tu sigUsU ese OgbesU Gurban yisUn boda”, “abaqai-tu sigUsUese OgbesU nigen yisUn boda-tu tabunang-tu sigUsU ese OgbesU tabun boda-tu” хэмээн нийгмийн дээд давхаргын хаан язгууртан нар болон тэдний хатадын эрх хэмжээг хуулиар баталгаажуулжээ.

“Халхын үйсэн цааз”-д XVI-XVII зууны үеийн Монголын нийгэм дэх эмэгтэйчүүдийг хатан, авхай, эм(эм хүн) хэмээн ялгаатай бичжээ. Хатан бол хаад ноёдын гэргий, авхай нь тэдний охин юм. Харин эм хэмээх нь язгууртны угсаа гарлын бус хүнийг заахын зэрэгцээ гол төлөв харц хүний эхнэрийг хэлж байгаа бололтой.

XVI-XVII зууны үеийн Монголын язгууртан ноёдын хатан, авхай нар нийгмийн дээд давхаргад хамаарч, эрх ямба эдэлж байжээ. Үйсэн цаазад Сэцэн хатан, Хотагур хатан хэмээх нэр гарч буй, *Модон барс жилийн өчүүхэн цааз*-ыг Хотагур хатан, Далай сэцэн хун тайжийн сүмийн өмнө хэлэлцсэн, авхай нарт шүүс өгөх, авхайг донгодвоос “биеийг нь алж, малыг нь талах” хүнд шийтгэл оногдуулахаар заасан зэрэг нь хатан, авхай нарын нийгэмд эзэлж байсан байр суурь, эрх ямбыг харуулна. Жишээ нь: “Зургаан хошууны их цааз”-д “хан хүн авхай хоёрыг дайрч донгодвоос биеийг нь алая, малыг нь талая”, “Авхайд шүүс эс өгвөөс нэгэн ест буй”, “Усан туулай жилийн цааз”-д “ноён хатан чамд донгоднам гэж худал хэлсэн хүний малыг нь хагаслах болов” хэмээжээ.

XVI-XVII зууны үед шигэчин, өрлөг, тугч, бүрээч, тайш, дархад, хонжин, шувуучин, шавь нар, хиа зэрэг хүмүүс (албан тушаалтан) нийгмийн давхрагын хувьд нэгэн бүлэгт хамаарч байсан бололтой. Үүнд, “Зургаан хошууны их цааз”-д “... sigecin OrlOgtuGci bUregeci darqad sabinar tayisi nar ede qulaGai kibesU qoyar yesUn dutaGun ab”, “Мичин жилийн их цааз”-д “...sigecin OrlUg tuGcin bUregecin tayisi darqad qonycin sibaGucin sabinarkiy-a nar edUn bUgUde qulaGai kibesU caGajani nigen bolba” гэх мэтээр заажээ¹¹.

“Халхын үйсэн цааз” дахь er-e (er-e kUmUn), em-e (em-e kUmUn) хэмээх нь хүйс заахаас гадна нийгмийн давхраажлын байдлыг илтгэж байна. Тодруулбал, er-e kUmUn, em-e kUmUn бол язгууртны угсаа гарлын бус хүнийг заахын зэрэгцээ em-e гэдэг нь гол төлөв харц ардын эхнэрийг хэлж байгаа бололтой. Монголын хууль цаазын дурсгал тухайлбал, Халх-Ойрадын 1640 оны “Их цааз”, “Халх

¹¹ Жич, Монголын түүхийн бусад сурвалж тухайлбал, “Цагаан түүх”-нд бичсэн qonjin, tayisi, jayisang, ger-Un noyan, darqad, cerbi, terigUlegci, OrlUgUd, kiy-a nar, tuGcinar, bUriyecin зэрэг албан тушаалын талаар монголч эрдэмтэн Klaus Sagaster нарийн тайлбар хийсэн байна. Үзнэ үү. Sagaster, *Die Weisse Geschichte (caGun teUke)*. pp.107, 213.

журам” дахь эр хүн, эм хүний холбоотой хэргийн бүрэлдэхүүн нь хүйс ялгахын хамт нийгмийн давхраажлыг илэрхийлж буй нь бидний санааг давхар гэрчилнэ.

Үйсэн цаазад *bosqaGuli* (босуул)-ын талаар тусгайлан зааж, хатуу чанд шийтгэх, тэднийг барьж ирсэн хүнийг сайшаан шагнах тухай өгүүлсэн нь тухайн үеийн Монголын нийгмийн эзэн-харьяатын ёсыг харуулахын зэрэгцээ Халх, Ойрад, Манж, Оросын хоорондын зөрчилөөс шалтгаалан дүрвэн нүүх явдал их байсныг илтгэнэ. Тухайлбал, Зургаан хошууны цааз (16 дугаар зууны хоёрдугаар хагас)-д *sigecin*, *OrlUg*, *tuGci*, *bUregeci*, *darqad*, *sabinar*, *tayisi*, Усан үхэр жилийн өчүүхэн цааз (1616 он)-д *yamutan*, *gOUsi*, *qonjin*, *sanjan* (*senjen?*), *siregetU*, *OrlUge*, *kOkelten*, *kiy-a*, *daruGa*, *darqad* гэж буй.

Халхын үйсэн цаазад дайсанд хүн, морь орхиж ирэх, гарт орсон дайсныг алахгүй, ганц хошуугаар дайсанд мордохгүй байх зэргийг хуульчилан заасан нь тухайн цагийн Монголын дотоод, гадаад улс төрийн байдал ээдрээтэй байсныг харуулна. Нэгэн жишээ гэхэд цааз бичигт *dayisun* (дайсан)-ны тухай заасан зүйл 10 гаруй удаа тохиолдож байна. Тухайлбал, “Зургаан хошууны их цааз”-д “*dayisun-tu kUmUn-i orkiji irebesU quyaG temege qoyar kOl morin-i ab*”, “*Gartur oroGsan dayisun kUmUn-i buu ala*”, “*GaGca qosiGun-bar dayisun-tur mordaju idebes[U] rban temege jaGun aduGun ab: noyad-yin Gool-un tus-tu dayisun-u tus-tu: ulaGan ese OgbesU jaGun mal arban berkeab*” гэх мэтээр өгүүлсэнээс үүнийг мэдэж болно. Түүнчлэн Халх-Ойрадын 1640 оны “Их цааз”-д “*mongGol. oyirad-du dayisun irebesU kele Og.tere kele sonoscu bayiji jaq-a-yin yeke noyad ese irebesU jaGun quyaG. jaGun temege.mingGan aduGu abqu.baG-a noyad ese irebesU arban quyaG.arban temege.jaGun aduGu abqu bolba* (*mongGol oyirad-un caGaja-yin bicig*. 2000. pp.23) гэсэн нь санаандгүй хэрэг биш бөгөөд бидний санааг давхар батлах юм.

Ийнхүү “Халхын үйсэн цааз” нь XVI-XVII зууны Монголын нийгэм дэх эзэн харьяатын ёсон, анги бүлгийн ялгаа, давхаргын онцлог болон дотоод, гадаад улс төрийн байдал зэргийг тусган харуулсан түүхийн үнэ цэнтэй сурвалж ажээ.

Халхын үйсэн цааз бол XVI-XVII зууны Монголын төр эрх зүй, хууль цаазын тулгуур сурвалжийн нэг юм. Үйсэн цаазад “*Төв их тор, төрсөн бие энх амгалангаар ахуй болтугай*” хэмээн заасан нь монголчуудын төрөө дээдлэх үзлийн тусгал болой.

Цаазын бичигт засаг барьсан ноёдын тогтоосон цаазыг “их цааз”, харин засгийн тайж нарын цаазыг “өчүүхэн цааз” хэмээн ялгавартай тэмдэглэжээ.

Долоон хошууны ноёдын хэлэлцсэн цаазыг “их цааз”, дөрвөн хошуу, зургаан хошууны ноёдын цаазыг “өчүүхэн цааз” гэж бичжээ.

Халхын үйсэн цаазад тэмдэглэсэн “долоон хошуу”, “зургаан хошуу”, “дөрвөн хошуу”-ны талаарх заалт, хэлэлцэн тогтоосон ноёд язгууртны угсаа гарвал, газар усны нэр зэрэг нь цаазын үйлчлэх хүрээг зааж байна.

Үйсэн цаазын агуулгаас монголчууд төрийн аливаа хэрэгт хариуцлагатай хандаж, хичээн ажиллахыг хуульчилан баталгаажуулж байсан нь харагдана. Тухайлбал, “yosun bariGsan tUsimed jaGalduqu-du soGtaji buruGu qaGalbasu aldanggitai bui”, “Ноёнд элч илгээхэд элч архи ууж золиговол хөл морь ав” хэмээжээ.

XVI-XVII зууны үеийн Монгол оронд аливаа ял, хэрэг, заргыг шүүх үүрэг бүхий хүнийг “ёс барьсан түшмэд” хэмээн нэрлэж байжээ. Ёс барьсан түшмэд нь ялт хүнийг шүүхдээ элч (гэрч) байлцуулах бөгөөд ганцаар буруу шүүх, согтуу үед хэрэг шүүсэн бол торгуул төлөх тухай заажээ. Энэ нь монголчууд тор ёс, хууль цаазыг чанд сахих, хэрэг заргыг шүүхэд хариуцлагыг эрхэмлэж ирсэн уламжлалыг харуулж байна. Тухайлбал, *Зургаан хошууны их цааз*-д “ялыг түшмэд ганцаар буруу хагалбасу нэг тэмээ тэргүүлэн тавт болов”, *Мичин жилийн их цааз*-д “аль ялтай хүн бөгөөс элчтэй яв, элч үгүй явбасу ялыг нь бүү хагалж ог”, “ёс барьсан түшмэд заалдахад согтож буруу хагалбасу алдангатай буй” гэжээ.

“Халхын үйсэн цааз”-ын дотор цаазыг хэрэгжүүлж эхлэх хугацаа болон хуучин цаазыг хүчингүй болгох тухай заасан зүйл цөөнгүй тохиолдож байгаа нь монголчуудын хууль цаазын өв уламжлал, хөгжлийг илэрхийлнэ. Тухайлбал, “Зургаан хошууны их цааз”-д “Сайхны чуулганаас урьдахыг үрэв” гэж тэмдэглэжээ.

“Халхын үйсэн цааз”-д XVI-XVII зууны Монгол дахь ялын торол, шийтгэлийн хэлбэр тусгагдсан байна. Үүнд,

- *Алах* (biy-e inU alay-a: mali-ni talay-a хэмээсэн нь хүний биеийг алж, малыг нь албанд хураахыг хэлж буй),
- *Торгох* (Ёс торгох, анз торгох, хөл морь авах. Халхын үйсэн цаазад nigen yisU (нэгэн ёс), Gurban yisU (гурван ёс), tabutu (тавт), jirGuGan yisU (зургаан ёс), yesUtU (сест) гэх мэтээр нэгэн есөөс эхлэн есөн ес хүртэл торгох тухай заажээ. Анз (anjū) хэмээх XIV-XVIII зууны Монголын түүхийн сурвалж болон хууль цаазын бичгээс үзэхэд нэгтгэс есөн малаар торгох хөнгөн ялыг хэлдэг байсан бололтой. Хөл морь ав (kOl morin-i ab) гэдэг нь тухайн хүний унасан морийг авахыг хэлж байна.
- *Золиг* (золио) авах (“Халхын үйсэн цааз”-д эм хүний тулд, малын тулд, ялын тулд хүн болон малаар золиг авах тухай заажээ)

- *Жанчих* (Үйсэн цаазад ирт үзүүртээр жанчих-гурван ёс, чулуу, модоор жанчих-нэгэн ёс, ташуур, нударгаар жанжих-тавт гэж буй)
- *Донгодох* (Цааз бичигт Боржигинд донгодвоос-тавт, элч хүнд ам донгодвоос нэгэн ес гэжээ) гэх мэт жишээг дурьдаж болно.

“Халхын үйсэн цааз”-д нүүдэлчдийн хэв хуулийн уламжлалд холбогдох зүйл заалт цөөнгүй байгаа нь эрт, дундад үеийн монголчуудын хууль цаазын хөгжил, онцлогийг харуулна. Тухайлбал, Зургаан хошууны цаазад “tOrOgsen jegege naGacu-aca bisi qulaGai-tai bolba”, “nayiji kUmUn-i arakilajiGunilajiirejU abuGsan Ori Ugei bolba”, “tabunang-yi qariyabasun nigen yesUn boda aqas noyaqan-i qariyabasun tabutu bolba: albatu kUmUn-i ekeneri qariyabasun nigen mori ab” хэмээн бичсэн байна.

“Халхын үйсэн цааз” бол XVI-XVII зууны үеийн Монголын уран зохиолын дурсгалт бичгийн нэг юм. Бид Монгол улсын Үндэсний номын санд буй “Халхын үйсэн цааз”-ын эх бичгийг Х.Пэрлээгийн хэвлүүлсэн хуулбартай харьцуулан тулгаж, латин үсгээр шинээр галиглах явцад үйсэн цаазын дотор байсан Чингис хааны есөн өрлөгийн магтаалын хэсэг хэвлэгдээгүй үлдсэн нь мэдэгдсэн юм.

Х.Пэрлээ *Халхын шинэ олдсон үйсэн цааз-эрхэмжийн дурсгалт бичиг* бүтээлийнхээ оршилд үйсэн номын дотор “...өрлөгүүдийн магтаал ...гэх мэтийн зүйлс байлцана”¹² гэж тэмдэглэснээс харахад тэрбээр үүнийг анзаарсан бөгөөд харин дараа судлахаар үлдээсэн бололтой.

Халхын үйсэн цаазын доторхи 001, 002, 004, 0023(a), 0024(b), 0026(b) дугаар нүүр*¹³ нь Чингис хааны “Их түгэл” (yеke tUgel)-ийн доторхи есөн өрлөгийн магтаалын шүлгийн хэсэг ажээ. Үйсэн цаазын 004 дүгээр хуудасны эхний мөрөнд бичсэнээр үүнийг jirGuGan tUmen-i yеke tUgeliin bicig (Зургаан түмний их түгэлийн бичиг) хэмээн нэрлэжээ.

Үйсэн дээр бичсэн энэхүү “Зургаан түмний их түгэлийн бичиг”-ийн агуулга нь Чингис хааны есөн өрлөгийн ач гавъяаг магтан сайшаасан байна. Их түгэлийн бичигт:

- | | |
|-------------------------|-----------------------------------|
| 1. jalayirdai muqulai | (001 дүгээр хуудасны 5-р мөр) |
| 2. boro[qu] | (001 дүгээр хуудасны 7-р мөр) |
| 3. tataridai siri qutuG | (002-р хуудасны 4-р мөр) |
| 4. boGarci | (004 дүгээр хуудасны 8-р мөр) |
| 5. torGan sira | (0023(a) дугаар хуудасны 2-р мөр) |
| 6. jarcidai cuu mergen | (0023(a) дугаар хуудасны 6-р мөр) |

¹² Пэрлээ, Х. *Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг*, 5.

¹³ * Энэ дугаар бол ХБНУ-ын Бонн их сургуулийн профессор Klaus Sagaster багшид буй үйсэн бичгийг сэргээн засварласан ажлын зургийн дугаар, харин / / тэмдэг дотор байгаа нь Х.Пэрлээгийн нийтлүүлсэн үйсэн цаазын галигийн дугаар юм.

- | | |
|-------------------------|-----------------------------------|
| 7. jebe | (0024(b) дүгээр хуудасны 1-р мөр) |
| 8. uriyanGqadai jelme | (0024(b) дүгээр хуудасны 6-р мөр) |
| 9. oyiradai qara kiruGu | (0026(b) хуудасны 4-р мөр) |

нарын есөн өрлөгийн нэр дурьдагдсан бөгөөд 0026(b) нүүрийн төгсгөлийн мөрөнд *yisUn OrlUg-Uud-i daGusba* хэмээжээ.

Халхын үйсэн цааз дахь Чингисийн 9 өрлөгийн магтаал нь “Зургаан түмний их түгэлийн бичиг” хэмээх нэртэй байгаа нь Монголын төр ёсны уламжлалд зургаан түмний талаар үзэл онцгой байр эзэлж байсныг мэдэж болно.

“Халхын үйсэн цааз” бол XVI-XVII зууны монголчуудын аж ахуй, соёлыг улируулан судлах бичгийн сурвалжийн нэг юм. *Халхын үйсэн цааз*-д монголчуудын амьжиргааны гол эх үүсвэр болсон нүүдлийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх, бэлчээрийг хамгаалах, мод хатгасан газар, цаазын цагаан сүрэг, зургаан хошуунаас мал адгуус гадагш гаргахыг хориглох тухай заасан нь нүүдэлчдийн аж ахуйн өвөрмөц арга, өв уламжлалыг харуулж байна. Тухайлбал, *мод хатгасан газар* хэмээх нь нүүдлийн ахуй байдлын онцлогыг илэрхийлэхийн зэрэгцээ монголчууд нэг газраас нөгөөд нүүхийн өмнө зохистой бэлчээр нутгийг сонгон, нутаг орны байц байдлыг шинжлэн үзэх арга ухааныг илтгэнэ.

Үйсэн цаазад таван хошуу малаас адуу, үхэр, тэмээ, хонь зэрэг малын нэр болон эдгээр малаар торгох заалт орсны зэрэгцээ араг, савар, аргал, түлээ зэрэг нүүдлийн аж ахуйн нэр томьёо бичигджээ. Эдгээр нь монголчуудын нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөх арга ухаан, уламжлалыг судлах чухал хэрэглэгдэхүүн болно. Жишээ нь үйсэн цаазад гарч буй араг бол “монголчуудын одор тутмын амьдралд олон зууны турш эдийн соёлын хүрээнд томоохон байр эзэлсээр ирсэн төдийгүй биет ба биет бус өв болон хадгалагджээ”¹⁴.

XVI-XVII зууны үед Халхын нутагаас гадагш адуу мал гаргахыг хориглон хязгаарлаж байсныг үйсэн цаазаас мэдэж болно. Тухайлбал, “Зургаан хошууны их цааз”-д “ene jirGuGan qosiGun-aca aduGusun GadaGsi GarGaji OgbesU nigen yesU-tU bui” (энэ зургаан хошуунаас адгуус гадагш гаргаж өгвөөс нэгэн ест буй) гэсэн нь тухайн цагийн Халхын дотоод байдал төдийгүй гадаад байдал нэн ээдрээтэй байсныг давхар харуулах юм.

Халхын үйсэн цаазын доторхи *Эр модон барс жилийн цааз*-д саGajai-in са-Gan sUrUng (цаазын цагаан сүрэг) хэмээн бичсэнээс үзэхэд тухайн цагт язгууртан, ноёдын чуулган чуулах үед хэрэглэх зориулалт бүхий сүрэг байсан бололтой.

¹⁴ Тангад, Д., Ариунтунгалаг, Г. “Монголын уламжлалт соёлыг судлах нэгэн оролдлого (араг саврын жишээн дээр)”, *Studia Museologica*. Tom. XVIII-I. Fasc. 9, 2017, 83.

Монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөх явцдаа таван хошуу малыг уналга, эдэлгээнд ашиглах олон зүйлийн тоног хэрэгслийг бий болгосон юм. “Халхын үйсэн цааз”-д малын тоног хэрэгсэлээс суран хазаар, модон эмээл, суран хударга, ташуур, дээс, ногт, чулбуур, чөдөр, олом, жирэм, тэвш, модон дөрөө, мөнгөн хазаар, мөнгөн хударга, нэмнээ зэргийн нэр гарч байна. Энд жишээ дурьдахад, Ч.Сонгино, В.Бүнчин “Бүх төрлийн малын арчилгаа, эдэлгээний тоног хэрэгсэл” бүтээлийнхээ “Уналгын адууны тоног хэрэгсэл” бүлэгт “Уналгын адууны тоног хэрэгсэл - залж жолоодох хазаар, ногт, эмээл, дөрөөний төрлүүд, гөлөм, олонцог, олом, жирэм, тохом, хурдны морины тоног хэрэгсэл, уналгын тэмээний тоног хэрэгсэл – залж жолоодох буйл, бурантаг, тохош, уналгын үхрийн тоног хэрэгсэл” гэх мэтээр ангилан нарийн тайлбарласан бол¹⁵ “Монгол адууны нэвтэрхий толь”¹⁶-д адууны уналга, эдэлгээтэй холбоотой эмээл, дөрөө, хазаар, амгай, зуузай, хударга, хөмөлдөргө, даруулга, жирэм, ногт, чөдөр, уурга, бугуйл, зэл, ташуур, хусуур, морин тэрэг, морины уяа зэрэг 10 гаруй тоног хэрэгсэл буйг тэмдэглэсэн нь үйсэн цаазын мэдээ үнэ цэнэтэй болохыг илтгэнэ.

“Халхын үйсэн цааз” дахь таван хошуу малын тоног хэрэгслийн төрөл зүйл нь нүүдлийн аж ахуйн онцлог, нүүдэлчдийн ур ухаан, өв уламжлалыг харуулж байна.

“Халхын үйсэн цааз”-д нүүдэлчдийн дайн байлдааны болон ан авын гол хэрэгсэл нум сум, сум, жад, нумын хөвч зэргийн талаар дурьдсан нь монголчуудын ан авын төрөл зүйл, уламжлалыг нэхэн судлах боломжийг олгоно.

Монголчуудын ан авыг агнуур явуулах арга хэлбэр, агнах амьтдын төрөл зүйлийг харгалзан “гөрөөлөхүй”, “загасчлахуй”, “шувуулахуй” хэмээх гурван төрөлдангилдаг¹⁷.

Монгол нутагт дахь тас (tas), харцага (qarcaGai), бүргэд (bUrgUd), болжмор, булга, шилүүс (silegUsU), халиу(qaliGu), тарвага, нохой, могой, мэлхий, ангир, галуу зэрэг амьтны нэр “Халхын үйсэн цааз”-д гарч байна.

“Мичин жилийн их цааз”-д “...могой, мэлхий, ангир, болжмор, галуу, нохой эднийг албасу нэгэн морьт” гэх мэтээр заасан нь ан амьтныг хамгаалах, нөөц баялагийг зохистой ашиглах тогтсон хэв ёсыг харуулахын зэрэгцээ монголчуудын дунд араатан амьтны олон зүйлийг ялган таних мэдлэг ухаан хөгжиж байсны гэрч юм.

¹⁵ Сонгино, Ч., Бүнчин, В. *Бүх төрлийн малын арчилгаа, эдэлгээний тоног хэрэгсэл*. Улаанбаатар: Адмон, 2005, 75-160.

¹⁶ Баянбат, Д. *Монгол адууны нэвтэрхий толь*. Боть I. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК, 2016, 316-367.

¹⁷ Сампилдэндэв, Х. *Малчин ардын зан үйлийн уламжлал*. Улаанбаатар: УХГ, 1985, 160; Батмөнх, Б. *Монголчуудын уламжлалт ан ав*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2005, 23.

Халхын үйсэн цаазаас үзэхэд XVI зууны сүүлч XVII эхэн хагаст монголчуудын дунд (Халх долоон хошуунд) шувуугаар ан хийх уламжлал хэвээр хадгалагдаж, тэдгээр хүмүүсийг шувуучин хэмээн нэрлэж байжээ. Үүнд,

Халхын үйсэн цаазад тас, харцага, бүргэд зэрэг махчин шувуу болон *sibaGucin* (шувуучин)-ы талаар тэмдэглэсэн нь тухай цаг үед шувуугаар ан ав хийдэг хүмүүс байсныг илтгэнэ. Тухайлбал, “Зургаан хошууны их цааз”-д “*tasbUrgUd qarcaGai-yin uraqa toor Gurban yisUtU bui: qarabajegesen yola tabutu bui*” “Мичин жилийн их цааз”-д “*tasbUrgUd qarcaGai-yin tour Gurban yisU-tU*” хэмээжээ.

Монголчууд харцага, шонхор, бүргэд зэрэг махчин шувууг тэжээн сургаж ан хийлгэхийг “*шувуулах*” гэж нэрлэж байсан¹⁸ бөгөөд монгол хэлний үгийн бүтэцийн үүднээс авч үзвэл, *sibaGucin* гэдгийн *cin* дагавар нь олон тооны утга илэрхийлж байна.

Д.Төмөртоогоо “Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа”¹⁹ бүтээлдээ “Эртний болон дундад үеийн монгол хэлэнд мал адгуус, ан араатан, эд юмсын холбогдолтой аливаа нэр үгийн язгуурт *ci* дагавар залгаж, тухайн зүйлийн эрхлэн үйлдэгчийг заасан нэр үг бүтээсэн байна” хэмээгээд дундад үеийн монгол хэлний үед *cin* дагавар олон тооны утга илэрхийлж байсныг *aGtacin* [=aGta+cin], *qonicin* [=qoni+cin], *ada'u:cin* [<adu'u: + cin] гэх мэт жишээ татан өгүүлжээ. Эндээс үзэхэд, *sibaGucin* хэмээх нь шувуугаар ан хийдэг хүмүүсийг зааж байгаа ажээ.

Халхын үйсэн цаазын мэдээ нь XVI-XVII зууны үеийн Монгол оронд нүүдлийн мал аж ахуйн зэрэгцээ гөрөөлөх, шувуулах зэрэг төрөл зүйлийн уламжлал хэвээр хадгалагдаж, тэдгээрийг эрхлэх тусгай хүмүүс байсныг харуулж байна.

“Халхын үйсэн цааз” нь XVI-XVII зууны монголчуудын эдийн соёл, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл, ахуй байдлын онцлогыг тусгасан сурвалжийн нэг юм. Үүнд,

Хувцас, хэрэглэлийн зүйлс: хуяг, өвч хуяг, тарваган дах, нэхий дээл, элгэн ууж, нэхий элгэн гутал, мөнгөн бүс, суран бүс, хоорог, даалин, хурганы арьс, хонины унгас,

Гэр ахуйн зүйл: богц, уут, үхэг, авдар, хутга, алх, сам, аяга, хайч, зүү гэх мэт одор тутмын эд хэрэглэлийн нэр тохиолдоно. Энэ бол монголчууд тухайн цагт эдгээр зүйлийг амьдрал ахуйдаа хэрэглэж байсны баттай гэрч баримт юм.

¹⁸ Эрдэнэбат, У. *Монгол шувуулахуй*. Улаанбаатар: Mongolica Publishing, 2014, 8, 54.

¹⁹ Төмөртоогоо, Д. *Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа (Уйгуржин монгол, дорволжин, араб, хятад үсгээр тэмдэглэсэн монгол хэлний дурасхалууд)*. Улаанбаатар: 2011, 88, 124.

Х.Нямбуу “Монгол хувцасны түүх” бүтээлдээ “Монголчуудын хувцасны хэв маяг нь Азийн нүүдэлчин түмнээс монгол туургатны ялгарах ялгаа, адилшуу төслөг шинжийг илэрхийлсэн байдаг”²⁰ хэмээн тэмдэглэсэн буй. Эндээс ургуулан бодвол, “Халхын үйсэн цааз” дахь хувцас хэрэглэлийн талаарх мэдээ нь нүүдэлчдийн өвөрмөц онцлог, соёлын илэрхийлэл болж байна.

Үйсэн цаазад богц, уут, үхэг, авдар, хайч, хутга, алх, сам, зүү зэргийн төрөл зүйлийг нарийн заагаагүй ч эдгээр зүйлийг монголчууд эдүгээ ч өдөр тутмын амьдралдаа хэрэглэсээр байгаа билээ. Тухайлбал, *авдар* (хийсэн эдээр: модон авдар, ширэн авдар, гэрт тавих орноор нь: бурханы авдар, гэрийн эзний авдар, гэрийн эзэгтэйн авдар г.м.), *хайч* (үйлийн хайч, төмрийн хайч, үсний хайч, галын хайч г.м.)²¹, сам (үсний сам, хөөврийн сам) зэрэг олон төрөл зүйл буй амуу.

Хар бухын балгаснаас олдсон үйсэн бичгийн дурсгал нь монголчуудын ном, бичгийн үүх түүхтэй салшгүй холбоотой. “Халхын үйсэн цааз”-ыг зарим тохиолдолд “Үйсэн ном”²² хэмээн нэрлэсэн байдаг. Учир нь уг сурвалж хэлбэрийн хувьд дэвтэрлэсэн буюу товхисон хэмээх монгол номын нэгэн төрөл зүйлд хамаарна.

Монгол номыг хэлбэрийнх нь талаас үзэхүл *сударчилсан*, *товхисон* буюу *дэвтэрлэсэн*, *пугалбар*, *хуйлмал* гэж лавтайяа дөрвөн зүйл ялгаатай байсан бөгөөд сударчилсан ном нь их төлөв шашин сургаалын хүрээнд, дэвтэрлэсэн ном нь голдуу улс төр, иргэний салбарт зонхилон хэрэглэгдэж байжээ²³.

Хар бухын балгаснаас олдсон үйсэн бичгийн дурсгалын дотор бурханы шашны сударыг мөн ном хэлбэртэй дэвтэрлэн үдсэн зүйл тохиолдож байгаагаас үзэхэд энэ нь тухайн цагийн ном бичгийн ёсны түгээмэл аргын нэг байжээ. Халхын төв нутагт хус модны үйсийг бичгийн хэрэгсэл болгон ашиглах явдал байсан бол “XVII зууны үед монголд үнсэн самбарт тэмдэглэл хийхээс гадна ноорог хийхэд хэрэглэдэг”²⁴ байв.

“Халхын үйсэн цааз”-ын эх бичгийг хар бэхээр бичсэн бөгөөд бичгийн хэв, зурлага зэргийг ажиглахул хулсан үзэг ашиглажээ. Монголчууд хулсан үзэг, модон үзэг зэргээр бичихийн зэрэгцээ бэх гаргаж авах өвөрмөц арга хэрэглэж байжээ. Х.Пэрлээ “уг хуулийг пухаж боловсруулсан хөө буюу хар бэхээр, хулсан үзгээр” бичсэн хэмээн үзсэн буй. Ж.Цэзэн монголчуудын бэх гарган авах аргын

²⁰ Нямбуу, Х. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар: Адмон ХХК, 2002, 24.

²¹ *Монгол нүүдэлчдийн тайлбар толь*. Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар, 2014, 168, 174, 204.

²² Пэрлээ, Х. *Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг*, 6.

²³ Шагдарсүрэн, Ц. *Монголчуудын утга соёлын товчоон*. Улаанбаатар: Эрдэм нүүс, 1991, 160.

²⁴ Лувсанбалдан, Х. Модон дэвтэр. *Studia Museologica*. Tom. II. Fasc.5, 1974, 40.

тухайд “Алт, мөнгө, зэс, ганг билүүдэж, билүүний баасыг цэвэр усанд тунгаахад үйрсэн алт, мөнгө, доор нь тунаж үлддэг байна. Хэд хэд дахин шүүсний дараа усыг ширгэтэл халаах гэх мэтээр бэх болгох нарийн аргыг хэрэглэдэг байсан”²⁵ гэжээ.

Монгол-Зөвлөлтийн (хуучин нэрээр) археологчид “Халхын үйсэн цааз”-ыг “Хар бухын балгасны нэгэн сувраганы нуранхайгаас олж нээсэн”²⁶ байдаг. Иймд үйсэн цааз нь монголчууд ном, бичигээ хадгалан хамгаалж ирсэн онцлогыг харуулах нэгэн зүйлийн баримт юм.

“Халхын үйсэн цааз” (үйсэн ном) нь XVI-XVII зууны монгол ном, бичгийн өв уламжлал, хөгжлийг илтгэх сурвалж болж байна.

Судлаачдын бичсэнээр ёс заншил, уламжлалууд нь тухайн угсаатны амьдрал үйл ажиллагааны түүх нийгмийн нөхцөлөөс хамаарч өөрчлөгдөж хөгжин бэхждэг. Түүхэн хөгжлийн явцад зарим уламжлал, ёс заншлууд бий болж байхад зарим нь алга болж, гурав дахь нь шинэ агуулгатай болохдоо хуучин хэлбэрээ хадгалдаг²⁷ аж. Арга зүйн энэ хандлагын үүднээс авч үзвэл “Халхын үйсэн цааз” дахь ёс заншил, зан үйлийн мэдээ баримт нь монгол ахуй, угсаа-соёлын судалгаанд чухал ач холбогдолтой.

Монголчуудын ёс заншил, ураг төрөл, хуримын зан үйлийн талаар үйсэн цаазад сонирхолтой мэдээ баримт агуулагдаж байна.

“Халхын үйсэн цааз”-д зааснаас үзэхэд XVI-XVII зууны үеийн Халхын ёсонд хурим гэрчтэй байх, охиноо хорин наснаас өмнө гэрлүүлэх, хошуу ноёноос зөвшөөрөл авах, охиныг өөрийн ноён хүргэний талд хүргэх, богтлох, инж өгөх, инж буцаах, эм татсан хүнийг шийтгэх, эр, эмийн зүй бус харилцааг тэвчих зэрэг журамтай байжээ. Тухайлбал, “Зургаан хошууны цааз”-д “гэрчгүй хуримыг үрьс: гэрчтэй болтугай: хорь насалсан охиныг өөрийн ноён хүргэний ноёнд хүргэж өг”, “Мичин жилийн их цааз”-д “эм татсан хүн нэгэн ест”, “хурим гэрчтэй болтугай, гэрчгүй хуримыг үрьс”, “Хорь насалсан охиныг өг”, “эм хүн эр хүний өвөрт орвол гурван естэй буй” гэжээ.

Халх ястан гэгдэх угсаатны бүлэг бүрэлдэн тогтох эх үндэс нь XVII зууны дунд үе, өөрөөр хэлбэл Гэрсэнз жалайр хунтайж, түүний үр ач нарын үед “Халх долоон хошуу”, “Халхын хаант улс” байгуулагдсантай холбогдон тэдний газар

²⁵ Цээн, Ж. *Монгол ном* (эрдэм шинжилгээний бүтээл). Улаанбаатар: “Урлах эрдэм” хэвлэлийн газар, 1999, 119.

²⁶ Пэрлээ, Х. *Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг*, 5.

²⁷ Цэрэнханд, Г. Монгол угсаатны түүхэн хөгжлийн зарим асуудал, *Монгол ахуй, угсаа, соёлын судалгаа*. 2014, 27.

нутаг, аж ахуй, эд өлөг, оюуны соёлын нийтлэг хэв маяг төлөвшсөн”²⁸ байна. Иймд үйсэн цаазыг Халх угсаатны бүлгийн оюуны соёл, нийтлэг хэв маягийг илэрхийлэх баримт хэмээн үзэж болно.

Халхын үйсэн цаазад тэмдэглэсэн зарим ёс, зан заншил нь хойч үед уламжлагдан өнөөг хүрчээ. Тухайлбал, XIX-XX зууны эхэн үеийн халхчуудын ураг төрлийн ёсонд хөвгүүнээ 18-25 наснаас, охидоо 17-21 наснаас нь өрх гэр болгож ам бүл, өмч хөрөнгө хуваан өгч тусгаарладаг заншил түгээмэл нийтлэг байжээ. Ер нь монголчууд охиноо 17 нас хүрэхэд “цусан тамир” нь бүрдсэн хэмээн эрд өгөх, 18 нас хүрсэн хөвгүүн “цусан цөмөг” нь бүрдсэн гэж үзэн ураг барилдуулах талаар эцэг, эх нь санаа тавьж эхэлдэг²⁹ заншилтай.

Үйсэн цаазын доторхи *Модон барс жилийн намрын цааз*-д “Ноёд тавнангуудад авхай дээр авхай өгвөөс, урьд авхайг инжтэй нь эцэг нь авах болов, тэр авхайд инж бүү өг, өгвөөс зуун адуу арван тэмээ авах болов” хэмээн тэмдэглэсэн нь тухайн цагийн хуримын зан үйлд инж өгөх болон инж буцаах ёс байсныг илтгэнэ.

Дүгнэлт

XVI-XVII зууны Монголын нийгэм дэх эзэн харьяатын ёсон, анги бүлгийн ялгаа, давхаргын онцлог болон дотоод, гадаад улс төрийн байдал зэргийг тусган харуулсан түүхийн үнэ цэнтэй сурвалжийн нэг нь “Халхын үйсэн цааз” болохыг түүнд агуулагдаж буй мэдээ баримт гэрчилж байна.

Монголчуудын төрөө дээдлэх үзэл, хуул цаазын уламжлал, хөгжлийг илтгэх сурвалжийн нэг нь Халхын үйсэн цааз мөн. Цаазын бичигт засаг барьсан ноёдын тогтоосон цаазыг “их цааз”, харин засгийн тайж нарын цаазыг “өчүүхэн цааз” хэмээн ялгавартай тэмдэглэжээ. Долоон хошууны ноёдын хэлэлцсэн цаазыг “их цааз”, дөрвөн хошуу, зургаан хошууны ноёдын цаазыг “өчүүхэн цааз” гэж бичжээ.

Халхын үйсэн цаазын мэдээ нь XVI-XVII зууны үеийн Монгол оронд нүүдлийн мал аж ахуйн зэрэгцээ гөрөөлөх, шувуулах зэрэг төрөл зүйлийн уламжлал хэвээр хадгалагдаж, тэдгээрийг эрхлэх тусгай хүмүүс байсныг илтгэнэ.

Монголчуудын ёс заншил, ураг төрөл, хуримын зан үйлийн талаар “Халхын үйсэн цааз”-д сонирхолтой мэдээ баримт агуулагджээ. Тухайлбал, XVI-XVII зууны үеийн Халхын ёсонд хурим гэрчтэй байх, охиноо хорин наснаас өмнө гэрлүүлэх, хошуу ноёноос зөвшөөрөл авах, охиныг өөрийн ноён хүргэний талд

²⁸ Цэрэнханд, Г. “Монгол угсаатны түүхэн хөгжлийн зарим асуудал”, *Монгол ахуй, угсаа, соёлын судалгаа*. 2014, 13.

²⁹ БНМАУ-ын угсаатны зүй. Боть I. Халхын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1987, 275.

хүргэх, богтлох, инж өгөх, инж буцаах, эм татсан хүнийг шийтгэх, эр, эмийн зүй бус харилцааг тэвчих зэрэг ёс журамтай байжээ.

“Халхын үйсэн цааз”-ын мэдээ баримтууд XVI-XVII зууны үед Халх нь язгууртан ноёд, ард иргэд, газар нутаг, төрийн эрх барих чуулган, хууль цааз бүхий өөрийн өвөрмөц соёл, зан заншил, нүүдлийн ахуй байдлаа хадгалсан тусгаар улс байсныг харуулж байна.

Abstract: One of the valuable history, culture and law traditions of the Central Asian nomads is the Khalkha Mongolian “Law Manuscript on the Birch Bark”. The Mongolian archeologist Х.Пэрлэ (Kh.Perlee) copied the Law on the Birch Bark in the cursive way, made its transcription with some explanations, and published it in Ulaanbaatar in 1978 for the researchers’ use. However, this copy has letter and word mistakes and it has no source pictures having difficulties in the use of it as the source. I have studied internal situation in the Khalkha Mongolia in the XYII century, noblemen’s activities and political relation history between the Khalkha Mongolia and Qing dynasty. One of the sources in this field is the Manuscript on the Birch Bark. The Khalkha Mongolian “Law Manuscript on the Birch Bark” is one of the written sources that give possibility to study Mongolian history, law, economy, culture, belief and literature in the end of the XYI century and at the beginning of the XYII century. Therefore, we aimed to consider the Khalkha Mongolian “Law Manuscript on the Birch Bark” feature and Mongolian history, law, economy, culture, belief and literature in the end of the XYI century and at the beginning of the XYII century in this article.

Ном зүй

1. Батмөнх, Б. *Монголчуудын уламжлалт ан ав.* Улаанбаатар: Соёмбо принтинг, 2005.
2. Баянбат, Д. *Монгол адууны нэвтэрхий толь.* Боть I. Улаанбаатар: Монхийн үсэг ХХК, 2016, 316-367.
3. *БНМАУ-ын угсаатны зүй.* Боть I. Халхын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үс. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1987.
4. Жигмэддорж, Э. *Халх-Манжийн улс төрийн харилцаа.* Улаанбаатар: Гэрэгэ принт, 2008.
5. Жигмэддорж, Э. Манж нар 1655 онд Халхыг зүүн, баруун гар болгон хуваасан уу? *Quaestiones Mongolorum Disputatae.* Tom. VII. Association for International Studies of Mongolian Culture. Tokyo, 2011, 118.
6. Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз” дахь Чингис хааны 9 орлогийн магтаал. *Eurasian Nomadic Pastoralism: History, Culture, Enviroment.* CNEAS Report 22. Center for Northeast Asian Studies, Tohoku University. Sendai, 2016, 27-47.

7. Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз дахь ноёдын удам угсааг тодруулах асуудалд”, *Historia Mongolarum*. Vol. XV. Fasc. 5. №474(36). 2016.
8. Лувсанбалдан, Х. “Модон дэвтэр”, *Studia Museologica*. Tom. II. Fasc.5, 1974.
9. *Монгол нүүдэлчдийн тайлбар толь*. Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар, 2014.
10. Нямбуу, Х. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар: Адмон ХХК, 2002.
11. Пэрлээ, Х. “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг”. Тэргүүн дэвтэр. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, *Monumenta historica*. Tom. VI. Fasc.1, 1974. 5-139.
12. Сампилдэндэв, Х. *Малчин ардын зан үйлийн уламжлал*. Улаанбаатар: УХГ, 1985.
13. Сонгино, Ч., Бүнчин, В. *Бүх төрлийн малын арчилгаа, эдэлгээний тоног хэрэгсэл*. Улаанбаатар: Адмон, 2005, 75-160.
14. Тангад, Д., Ариунтунгалаг, Г. “Монголын уламжлалт соёлыг судлах нэгэн оролдлого (араг саврын жипхэн дээр)”, *Studia Museologica*. Tom. XVIII-1. Fasc. 9, 2017.
15. *Халхын үйсэн дээр бичсэн хууль цааз*. Монгол улсын Үндэсний номын сан, Бүртгэлийн дугаар 8590.
16. Төмөртоогоо, Д. *Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа (Уйгуржсин монгол, дорвөлжин, араб, хитад үсгээр тэмдэглэсэн монгол хэлний дурасхалууд)*. Улаанбаатар: 2011.
17. Цэзэн, Ж. *Монгол ном* (эрдэм шинжилгээний бүтээл). Улаанбаатар: “Урлах эрдэм” хэвлэлийн газар, 1999.
18. Цэрэнханд, Г. Монгол угсаатны түүхэн хөгжлийн зарим асуудал, *Монгол ахуй, угсаа, соёлын судалгаа*. 2014.
19. Chiodo, E and Sagaster, K. “The Mongolian and Tibetan Manuscript on Birch bark From Harbuhyn Balgas: A Preliminary Description”, *Zentralasiatische Studien*, 25, 1995, 28-42.
20. Chiodo, E. “A Mongolian Hymn to Qongsim Bodisung on birch bark from Harbuhyn Balgas (Bulgan aimag)” in *Ural-Altäische Jahrbücher*. Neue Folge 15. Harrassowitz verlag, 1997/1998, 223-249.
21. Choido, E. “Some observations on two texts to avalokitasvara from Harbuhyn balgas”, in *Mongolica* (An International Annual of Mongol Studies). Vol.10 (31). Seventh International Congress of Mongolists Vol. II, 2000, 369-378.
22. Chiodo, E. “On the Identification of a Mongolian Dharani from Harbuhyn Balgas”, in *Ural-Altäische Jahrbücher* Neue Folge 18. Harrassowitz verlag, 2003/2004, 123-140.

23. Chiodo, E. "Die mongolische Manuskripte auf Birkenrinde aus Charbuchyn T Balgas", *Dschingis Khan und seine Erben: Das Weltreich der Mongolen*. Exhibition Catalogue. Munchen: 2005, 112-116.
24. Chiodo, E. *The Mongolian Manuscripts on Birch from Xarbuchyn Balgas in the Collection on the Mongolian Academy of Sciences*. Part 1. Harrassowitz Verlag, Wiesbaden: 2000, 305 p+facsimiles.
25. Chiodo, E. *The Mongolian Manuscripts on Birch from Xarbuchyn Balgas in the Collection on the Mongolian Academy of Sciences*. Part 2. Harrassowitz Verlag, Wiesbaden: 2009, 338 p +facsimiles.
26. Шагдарсүрэн, Ц. *Монголчуудын утга соёлын товчоон*. Улаанбаатар: Эрдэм пүүс, 1991.
27. Эрдэнэбат, У. *Монгол шувуулахуй*. Улаанбаатар: Mongolica Publishing, 2014.